

**Д. Дашцэдэн**

Монголчуудын бүтээсэн оюуны соёлын томоохон бүтээл бол монголын нууц товчоо бөгөөд энэ нь зөвхөн монгол хэл, уран зохиол, түүхийн дурсгал бичиг төдийгүй хууль цаазны нэн чухал ач холбогдолтой сурвалж мөн. Монголын нууц товчоог оросын эрдэмтэн П. Кафаров, А. М. Позднеев Зөвлөлтийн эрдэмтэн С.А. Козин, Б.Я. Владимирцов мөн гадаадын бусад олон эрдэмтэн, Монголын Ц. Дамдинсүрэн, Х.Пэрлээ нарын зэрэг эрдэмтэн түүх, угсаатны зүй, монгол хэл, уран зохиолын талаас нь нэлээд нарийвчлан судалсан байна. Монголчуудын хууль цаазны сэтгэлгээний баялаг өв уламжлал бүхий энэ алдарт бүтээлийг хууль цаазны шинжлэх ухааны үүднээс нягтлан судалсан зүйл одоо хэр бараг үгүй бөгөөд харин эрдэмтэн Х.Пэрлээ нууц товчоонд үлдсэн хууль цаазны зарим асуудлыг судалж 1962 онд нэгэн сонирхолтой өгүүлэл хэвлүүлжээ.<sup>1</sup> Х. Пэрлээ энэ өгүүлэлдээ нууц товчоонд гардаг «Жүкэли» буюу «тахилга», видан (бугау) «хэмээх дөнгө» зарим ялын тухай, «анд бололцох болзооны тухай» «Шишигтэн» хэмээх цэрэг, байлдааны олз, өртөө улаа, албан татвар, өглөг, соёрхол, тэтгэврийн тухай зэрэг хууль цаазны зарим асуудлыг авч үзэж нэлээд үндэслэлтэй тайлбар өгсөн байна. Энэ нь нууц товчоонд байдаг хууль цаазны асуудлыг нарийвчлан судлахад ач холбогдолтой болох нь дамжиггүй.

Х. Пэрлээ, монголын нэгдсэн улс байгуулахын өмнөхөн үеийн хэв хууль, нэгдсэн улс байгуулсны дараахан үеийн аман ба бичигдэл хуулийн дурсгалаас нууц товчоонд хэсэг бусаг зүйл үлджээ гээд тэдгээр үлдэц нь нэрд гарсан Чингис хааны «Каса» хууль ба Өгөдэй хааны үеийн хууль цаазыг сэргээн мэдэхэд сурвалж болно гэдгийг онцлон тэмдэглэжээ.<sup>2</sup>

Нууц товчоонд буй Монголын тэр цагийн хууль цаазны дурсгалыг задлан шинжлэхэд монголчуудын зан заншил, заншлийн эрхийн хэм хэмжээ, мөн бичигдмэл болон аман хууль зарлигийн хэм хэмжээ гурав нэг дор хутгалдан байгаа нь ажиглагдаж байна. Иймээс эдгээр гурвыг ялган үзэх нь нууц товчоонд байгаа хууль цаазны асуудлыг зөв ангилан үзэж төрөлжүүлэх, үнэлж дүгнэхэд нэн чухал ач холбогдолтой болно.

Нууц товчоонд байгаа хууль цаазны зарим зүйлийг эрүү, иргэн, төр, захиргаа, гэр бүлийн холбогдолтой хэмээн ангилан үзэж болох байна.

**Эрүүгийн холбогдолтой зүйл** нь өшөө хонзон авах, дөнгө зүүж айл хэсүүлэн хорих, нэгжих, дээрэм хийх, хүн алах, шүүх таслах, зарга шүүх зэрэг болно. ХП зууны үед монгол аймгуудын дотор өшөө хонзон авах нь нэлээд дэлгэрэнгүй үзэгдэл байжээ. Энэ нь эхний үед нэг аймаг нь нөгөө аймгаас заавал өшөө авч хэн нэгийг нь алах, хүйс тэмтрэх, эсхүл хорлох, харин хожуу буюу ХП зууны дунд үеэс гол төлөв дайн байлдаан хийж хонзонгоо тайлах зэргээр илэрч байжээ.

Нууц товчоонд дурдсанчлан өшөө хонзон авах нь монголын хэв хуулийн нэг төрөл болон заншлын эрхийн хэм хэмжээгээр зохицуулагдаж тэр нь «нүдийг нүдээр», «чихийг чихээр» гэсэн эртний цусан өшөө үргэлжлэн байсан гэж үзэх үндэстэй байна.

Амбагай хаан татаар аймагт баригдаад хөвүүддээ элч илгээж өшөөгөө авахыг хэлүүлсэн нь чухамдаа цусан өшөө авах нэгэн хэлбэр байсан гэж үзэх үндэстэй байна. Энэ тухай нууц товчооны 53-р зүйлд заасан нь: Би татаар аймагт баригдав. Таван хурууны хумсыг тамтартал, арван хуруугаа барагдтал миний өшөөг авахыг оролдогтун.

Заншлын эрхийн энэ зарчмыг үндэс болгон нууц товчооны 58 67, 76, 77, 78, 102, 105, 113, 133, 136-р зүйлүүдэд өшөө авах тухай заасан байна. Цусан өшөө авахтай адил бүхий заншлын эрхийн энэ хэм хэмжээ нь аажмаар гээгдэж улмаар өшөө авах нь хожим байлдааны хуулиар зохицуулагдах болжээ.

ХП зууны үед монгол аймгуудын дотор ялтан буюу баригдагсдыг айл хэсүүлэн хорих хадгалах арга хэрэгсэлтэй байсан гэж Х. Пэрлээ энэ талаар тодорхой бичсэн<sup>3</sup> байна. Үүнийг нууц товчооны 81, 84-р зүйлээс ч мэдэж болно.

Нууц товчоонд дурдсан эрүүгийн зүйлд хамаарах нэг асуудал бол нэгжлэг юм. Ялтан, баригдагсдыг эрж олохын тулд айл бараанд нэгжлэг хийж ялтан хүнийг нуусан байвал хатуу шийтгэдэг байжээ. Энэ тухай Тэмүүжин тайчуудад баригдаж оргоод нуугдсан, улмаар тайчууд Тэмүүжинг олохын тулд айлуудаар нэгжлэг хийсэн, Сорхон шар Тэмүүжинг хэлэлгүй нуусан зэргээс мэдэж болно.

Нууц товчооны 87-р зүйлд: Тэр нэгжүүлийг одсон хойно Тэмүүжинд Сорхон-шар өгүүлрүүн: «Намайг үнсээр хийсгэн алдав чи. Одоо даруй эх ба дүү нарын зүг яв» гэжээ.

Нууц товчоонд үлдсэн эрүүгийн холбогдолтой зүйл бол дээрэм хийх, хулгай хийх, хүн алах зэрэг тодорхой төрлийн гэмт хэргийн шинжтэй тухай дурдсан явдал мөн. Нууц товчооны 90-р зүйлд Тэмүүжиний найман шарга агтыг харсаар байтал дээрэмдэж явсан, 131-р зүйлд Хатагин овгийн нэгэн хүн морины уяанаас цулбуур хулгайлсан, 136-р зүйлд хэлсэн үгэндээ хүрээгүй Сача, Тайчу хоёрыг бүтээж алсан, 188-р зүйлд хаан эзнээ хаяж ирсэн агтач Хөхөчүг цавчиж алсан тухай дурдсан байдаг.

Нууц товчоонд бичсэнээс үзвэл дээрэм, хулгайн хэрэгт оногдуулах тодорхой ял байсан нь мэдэгдэхгүй байна. Харин дээрэмдүүлсэн буюу хулгайд алдсан зүйлээ нэхэн хөөж биет байдлаар нь эргүүлэн олж авах зэрэг өөрөөр хэлбэл дээрэмдэлцэх, хулгайлалцах заншлын эрхийн хэм хэмжээ монгол аймгуудын дотор нэлээд дэлгэрэнгүй байсан бололтой.

Хэлсэн үгэндээ хүрээгүй буюу тангарагаа няцсан, хүн алсан хүнийг нэн ялангуяа хаан эзэндээ үнэнч бус хандагсдыг заавал алдаг хатуу журам Монголын хаадын дотор үе улиран уламжилж ирсэн шинжтэй байна. .

Нууц товчоонд аливаа хүнийг алах тухай зүйл үлдсэн байна. Нууц товчооны 201-р зүйлд: Шалтгаан үгүй аминд хор хийвээс үл зохимуй. Хүнд мөрт хүн би. Энэ их шалтгаан нь өгүүлрүүн: Энэ заалт нь аливаа хүнийг алахад хүндтэй шалтгаан заавал хэрэгтэй, ялангуяа дээд язгуурын хүнийг алахад тодорхой шалтгаан бүхий хуультай байсныг гэрчилж байна.

Нууц товчоонд монголын дундад үеийн эрүүгийн хууль цаазны зарим дурсгал үлдсэний нэг хэсэг нь улсын дээд шүүгчийг бий болгож, шүүн тасалсан хэргүүдийн тухай тэмдэглэсэн явдал юм.

Энэ бол **нэг талаар**, хууль цаазыг бэхжүүлэхээр авсан зохион байгуулалтын шинжтэй томоохон арга хэмжээ, **нөгөө талаар**, шүүн таслах эрхийг төрөөс албан ёсоор эрхлэх болсны илрэл мөн.

Нууц товчооны 203-р зүйлд энэ тухай дурдсаныг Х. Пэрлээ орчуулан нийтлүүлжээ.<sup>4</sup>

Монголчууд Чингисийн үеийн төрт ёсноос уламжлалтай хууль цаазны энэ уламжлалыг өнө удаан жил гээлгүй хадгалсаар ирсэн бололтой. Үүнийг «улаан хацарт», «Хугархай нүүрт» зэрэг XIX, XX зууны үед шийтгэсэн хэргийн тэмдэглэл данс гэрчилж байна гэж үзэж болох юм.

Нууц товчооны 241-р зүйлд (Борохулын хүүр ясны тулд) түүний гэр бүлд түмэдийн 100 хүнийг өгсөн байна. Энэ бүх баримт нь монголын хожуу үеийн тухайлбал XVII зууны хуульд алагдсан хүний (ор босгох) ял гэж дурдсантай их адил болох тул, Монголын ор босгох хууль XIII зууны үеэс уламжлалтай байж болох байна хэмээн Х. Пэрлээ бичсэн нь үндэстэй юм.

Нууц товчоонд аливаа хүнд ял унагах (оноох) аливаа хэргийг таслан барагдуулах өөрөөр хэлбэл хэргийн харьяаллын тухай хоёр зүйл үлдсэн байна. Жишээ нь нууц товчооны 201, 277-р зүйлүүдэд юуны өмнө аливаа гэмтэнд ял унагахад тодорхой шалтгаан хэрэгтэй болох, мөн хээр аян дайны үед өдүүлсэн хэргийг хээр дайны газар дээр нь таслан барагдуулах, гэрт буюу улсдаа байхад өдүүлсэн хэргийг гэрт, улсын дотооддоо нэгэн тийш болгон дуусгахыг заасан байна.

**Иргэний цаазад холбогдох зүйл нь** өмч, түүнийг хуваах, өв өвлөх гэрээслэл, тахилга, анд бололцох болзоо, худалдаа наймааны тухай зэрэг болно. Монголд өмч өмчлөх, өмч хуваах, гэрээслэх, өв залгамжлах ёс эртний уламжлалтай байсан байна.

Алун-гуаг нас барсны хойно түүний хөвүүд Бэлгүнүтэй, Бүгүнүтэй, Буха хатаги, Бухату салжи нар адуу малаа хувааж авсан дүү Бодончарт хувь өгөөгүй тухай мэдээ болно.

Нууц товчоонд үлдсэн хууль цаазны нэлээд эртний үлдэц нь «Жүкэли» тахилга, «Йэкэс-э Гахар»-ын тахилгад оролцогчдын тухай шууд бус заалт болохыг Х. Пэрлээ задлан шинжлээд «X зууны үед монгол овог тус бүрдээ тахилгатай, тэр тахилгад оролцогчдын тухай аман хэв хуультай байсан тухай бичжээ».<sup>5</sup>

Энд тахилгыг хууль цаазны үлдэц гэх нь оновчтой бус байна. Харин «Тахилга» нь монголын ард түмний зан заншлын холбоотой үлдэц тахилганаас хувь хүртэх, түүнтэй холбогдох маргаан зэргийг иргэний цаазад хамаатуулан үзэх нь илүү үндэстэй юм. Мөн нууц товчооны 242-р зүйлд Чингис хааны зарлигаар эх, хөвүүд, дүү нартаа иргэн хувааж өгсөн тухай дурдсан байна.

Түүнчлэн Чингисийн их засаг хуульд татвар эмээс төрсөн хүүхэд хууль ёсонд тооцогдон эцгийн гэрээсэлснээр хөрөнгийг хуваах үед хувь авах эрхтэй, ахмад хөвгүүд дүү нараас илүү хувь авах, отгон хөвгүүн эцгийн гэр барааг залгамжлах, хөвгүүдийн ахмадыг тэдгээрийн эхийн дэс дараагаар тогтоох<sup>6</sup> зэргийг заасан байдаг. Түүнчлэн академич Ш. Нацагдорж, манай монголын эрхийн тулгар бичгүүдэд өв хөрөнгийг залгамжлах тухай заалт байдаг<sup>7</sup> гэжээ.

Жишээлбэл: нууц товчооны 70-р зүйлд 1163 оны хавар Хамуг Монголын хаан байсан тайчуудын Амбагайн бэлбэсэн хатан Орбай, Сукадай, Есүгэй баатрын бэлбэсэн эхнэр Өэлүн гурав монгол аймгуудын тэргүүлэгчдийн өвгө дээдсийн оршуулсан газрын идээны хувь өгөх, авах тухай хэрэлдсэн нь чухамдаа тахилгын иргэний хууль цаазын асуудал мөн.

Тэр үед тахилгын идээ өгөх, авах тухайг зохицуулах бичигдэл хууль байгаагүй учир заншлын эрхийн хэм хэмжээгээр зохицуулж байсан бололтой.

Монголын нэгдсэн улс байгуулагдахаас өмнөхөн үед холбогдох иргэний хууль цаазын зүйл нь анд бололцох, болзооны тухай заншлын хэм хэмжээ болно. Нууц товчооны 96, 108, 116, 117-р зүйлүүдэд анд бололцох тухай дурдсан байдаг. Жишээ нь XI зууны дундуур үед Есүгэй баатар Хэрэйдийн Тоорил хоёр бас ХП зууны эцсээр Тэмүжин, Жамуха нар анд бололцсон тухай дурджээ.

Анд бололцох, болзоо хоёр нь хэдийгээр заншлын эрхийн заалттай боловч иргэний хууль цаазын тодорхой агуулгатай байжээ. Энэ учраас анд бололцоход заншлын эрх ёсоор үүрэг хүлээдэг, мөн болзоо нь андгайлах буюу тангараглах заалттай байжээ.

Нууц товчооны 117-р зүйлд анд бололцогсдын үүргийн тухай: Анд хүн амин нэг ч үл тэвчилдэн (эвдрэлцэхгүй), амины арьч (аврал) больё гэж амраглах ёсон тийм буй.

Нууц товчооны 108-р зүйлд буй болзооны тухай заншлын хэм хэмжээ нь:

«Бороотой байсан ч  
Болзоондоо ирье,  
Хуртай байсан ч  
Хуралдаа бүү хожидъё»

гэж монголоор андгайлан хэлэлцсэн биш үү? Зээ гээд хожидсоныг зэргээс хасаж гаргая! хэмээсэн биш үү?

Заншлын эрхийн энэ үлдэц нь одоо болтол манай ардын дуунд үлдсэнийг Х. Пэрлээ онцлон тэмдэглэсэн байна.<sup>8</sup>

Нууц товчоонд үлдсэн иргэний хууль цаазын нэг зүйл бол худалдаа, наймааны тухай болно. Нууц товчоонд дурдсанаас үзхүл монгол аймгуудын дотор ан хийх, түүний арьс үсийг худалдах наймаалах нь нэлээд дэлгэр байсан бололтой. Нууц товчооны 182-р зүйлд Сарта хулын (Туркестаны) Хасан гэдэг цагаан тэмээтэй хүн Онгудын Ала хуш-дигитхуриас мянган хонь (иргэ) аваад бас далимд нь Эргүнэ мөрний орчим нутаглах ардаас булга, хэрэм худалдан авч улмаар Балжун нуурт тууж явсан хонио усалж байхад нь Чингис хаан түүнтэй уулзсан тухай дурдсан байдаг. Энэ нь ХП зууны дунд үед монголчуудын дунд иргэд хоорондын худалдаа нэлээд хөгжсөн байсныг гэрчилж байна.

**Төр, захиргааны холбогдолтой зүйл нь** төрийн бодлого явуулах хууль, зарлиг гаргах, албан тушаал эрхлэх, цол хэргэм олгох соёрхол хүртээх, албан татвар авах, ядуучуудад туслах, өртөө улаа шүүс залгуулах, хотын дарга томилох, нутаг бэлчээр хуваарилах, ан гөрөө хийх газар сонгож авах, зарц эзэмших зэрэг болно.

ХП зууны үеийн монголчуудын төрийн бодлого нь урьдын их уламжлалаа хэвээр хадгалж Монголын нэгдсэн улс байгуулагдсанаас хойш төрийн бодлого нь нэлээд хөгжиж сайжирсан байна. Нууц товчооны 69-р зүйлд Есүхэйг нас барсны дараа туурга цэрэг (торгон цэрэг)-ээ бэхжүүлэх, улс төрөө байгуулах, 81, 85-р зүйлд Тэмүжинг Таргудай-Хирилтуг барьж улсдаа аваачаад засаглан шийтгэсэн, 121-р зүйлд төрийн хэргийн тухай, 123-р зүйлд Тэмүжинг хаан болгосон, түүний зарлигийг дагаж явах, 134, 141-р зүйлд цол хэргэм хааны тухай, 145, 147, 157, 198, 245-р зүйлүүдэд Чингисийн зарлиг, 149, 188, 200-р зүйлүүдэд түүний түшмэл, сайдууд хаан эзэндээ үнэнч байх,

1202 онд Чингис хаан бичмэл цааз тогтоож зарласан, 153-р зүйлд тогтоосон цаазыг зөрчих, 154, 202-р зүйлд төрийн хурал зөвлөлдөөн, төрийн нууц алдсан, 191-р зүйлд цэргийн хуулийн тухай, 196-р зүйлд төрийн тамга тэмдгийн талаар, 203-р зүйлд төрийн соёрхол, 212, 283-р зүйлд цэргийн зохион байгуулалт, 216-р зүйлд Монголын төр ёсонд бэхи ноёдыг өргөмжлөх заншил, 218-р зүйлд төрөөс өнчдөд үзүүлэх тусламж, 234-р зүйлд зарга шүүх, 243-р зүйлд хааны зөвлөх, 151, 249, 280-р зүйлд татвар, 246-р зүйлд донгодох тухай, 257-р зүйлд хан Мэлигийн цэрэг захирах эрхийг хассан, 263-р зүйлд хотын даргын тухай, 279-р зүйлд нутаг хуваах, өртөө улаа шүүсийн тухай заасан нь чухамдаа монголын эзэнт улс байгуулахаас өмнө ба түүнээс хойш үед Монголын төрийн бодлого өөрийн гэсэн нэлээд эртний уламжлалтай боловсронгуй байсны нотолгоо юм. Нууц товчоонд дурдсанаас үзхүл, монголчууд эртнээс уламжлан хууль, зарлигийг аман ба бичгийн хэлбэрээр гаргаж ирсэн түүнийгээ сайтар биелүүлдэг байсан нь харагдаж байна. Монголчуудын зарлигийг сайн дагаж биелүүлдэг тухай Марко Поло «зарлиг тушаалыг ертөнцөд хосгүй сайн дагаж гүйцэтгэнэ»<sup>9</sup> гэж бичжээ. 1206 онд Чингис «их засаг»-ийг<sup>10</sup> тогтоосон ба 1223 онд Чингис хааны зарлиг бичмэл хэлбэрээр гарч байсан<sup>11</sup> жишээтэй.

Чингис хаан болоод төр ёсыг эмхлэн цэгцлэж төрийн зарим албан тушаалыг бий болгож өөрийн итгэлтэй хүмүүсийг төрийн тодорхой албан тушаалд томилсон байна. Нууц товчооны 124, 125-р зүйлд Өнгүр, Сүйхэрү чэрби, Хадаан-далдурхан, Дэгэй, Гүчүгүр, Додой чэрби, Хувилай, Чилгутай, Хархан-Тохураун, Бэлгүтэй, Харалдай тохураун Хуту, Моричи, Мулхалху, Архай хасар, Тахар, Сүхэхэй, Чаурхан, Сүбээдэй, Боорчи, Зэлмэ нарыг буурч (тогооч), хонь хариулагч, тэрэгчин, гэргий хүүхэд ба зарц нарыг захирагч, адуу маллагч, газарчин, орд сахигч, бүгдийг ахлагч (захирагч)-ийн тушаалд томилоод энэ тухайгаа Чингис хаан хэлснийг нууц товчооны 125-р зүйлд дурдсан нь: Тэнгэрт өршөөгдөж, газарт ивээгдэж, Жамухаас салж намайг сэтгэж нөхөрлөө гэж ирсэн анхны өлзийт нөхөд минь аминаас ч илүү хүндтэй байх учиртай тул ийнхүү та нарыг зохих зохих тушаалд томилов гэжээ, Төрийн албаны тодорхой хуваарь байсан болохоор гавьяа байгуулсан хүмүүсийг шагнах «цол» хэргэм байсан юм. Гэхдээ монголын нэгдсэн улс байгуулахаас бүр өмнө хан, ван гэх мэт цол хэргэм байсан билээ. Монголын төр ёсонд ноёны зэрэг хэргэмтэй зарим хүнийг бэги болгох ёсон байжээ. Гэхдээ ахмад үеийн хүнээ бэги болгодог заншилтай байв. Нууц товчоонд Усун өвгөнд эрх олгож бэги цол хүртээсэн тухай дурдсан байна. Нууц товчооны 216-р зүйлд: Чингис хаан: Монголын төр ёсонд ноён мөр -бэги болгох ёсон ажгуу. Баарин ахыг уруг болгоё. Бэги мөр бидний дээд эцэг. Усун өвгөн бэги болтугай! Бэги өргөмжлөөд: Цагаан дээл өмсөж,

Цагаан агт (морь) унаж,

Дээд сууринд сууж бас он

сарыг олж сонгож байтугай гэж зарлиг болгов гэжээ.

Чингис хааны тогтоон олгож, хойшдоо мөрдөж Шиги-Хутагын Хөх дэвтэрт бичиж ирсэн төр ёсны нэгэн зүйл бол эрх ямба, соёрхлыг олон хүнд олгосон явдал билээ.

Нууц товчооны 203—223-р зүйлүүдэд Шихи-Хутаг, Мэнлиг, Боорчи, Мухулай, Хорчи, Жорчидай, Хубилай, Гэнигэдэй Хунан, Зэл Мэ, Толун, Үнгүр, буурч (тогооч) Борохул, Охиураг, Усун өвгөн, Хуйлдарын хөвгүүд, Нарил Тоорил, Сорхан-шар, Наяа, Зэв, Сүбээдэй,

Дэгэй, Гүчүгүр, Мулхалху нарт соёрхол үзүүлж улсыг байгуулахад зүтгэсэн түмний ноёд мянганы ноёд, зууны ноёд, арваны ноёд болгож, бусад олон хүмүүст соёрхлыг өгсөн тухай дурдсан байдаг. Энэ тухай Х. Пэрлээ нэлээд дэлгэрэнгүй бичсэн болно. Соёрхол өгөх нь Чингисээс хойш үед уламжлагдаж Х зууны эхэн хагаст төрийн том цуглаан хуралдай хийх үед тухайлбал өвөл цагийн их цуглаан дээр ноёд гавьяа байгуулсан хүмүүст их шан соёрхол түгээдэг байсан тул түүнд хэрэглэх эд зүйл элдэв хэрэглэлийг тусгайлан бэлтгэж арвижуулж улсын сан хөмрөг байгуулах болсон байна. 1240 оноос өмнөхөн Өгөдэй хаан «өглөг соёрхлын сан» байгуулах хууль гаргажээ. Энэ хууль нь нууц товчооны 279-р зүйлд байна. Бас ах дүү чуулбал өчлөг соёрхол өгье. Агуурс, Сүх, Годилнум, Хуяг, Зэв, Цан Тусурч (тусгаар лаж) балгад сахиульъя. Зүг зүгийн балгачин, амучин ялгаж (гаргаж) сахиултугай.

ХШ зууны эхэнд буюу 1201 онд Тэмүжин харьяат нараасаа (алба) гувчуур татаж ван хааныг тэжээсэн мэдээ нууц товчооны 151-р зүйлд бий. Энэ нь монголын аймгуудад алба гувчуур гувчдаг байсны гэрч юм.

1201 — 1230 Хэдэн он хүртэл 40-өөд жилийн дотор монгол улсын албан татвар их байсан боловч энэ тухай хууль дүрэмгүй байжээ. Албан татварыг эзэлсэн орны ард түмнээс, мөн өөрийн харьяат иргэдээс авдаг байжээ. Жишээ нь нууц товчооны 249-р зүйлд Тангудын Хашин хан Бурхан Чингисийн дагаар орохдоо тангуд иргэдээс тэмээ татварлаж тууж ирсэн тухай дурдсан байна.

Тангуд иргэнээс тэмээн гувчуур тууж авчирч өгөв. Нууц товчооны 279-р зүйлд: Хааны эцэг юүгээн бэлэнд (бэлэн сууринд сууж иргэ (н) үл зовоон, шөлөнд эд улсаас сүргийн нэгэн шүлэг (төлөг) хонин он онд өгтүгэй.

...Зүг зүгийн Мянгад мянгадаас гүүд гаргаж саагаад саарилчин (саальчин) таныг адуулаад, нундугч (нутагч таныг оршин талд (ан гид) гаргаж унагачин болтугай.

Өгөдэй хааны үед тогтоосон төр, захиргааны эрхийн холбогдолтой нэг сонин зүйл бол ядуучуудыг хаан төрөөс тэтгэж байсан тухай 1240 оны хуульд тусгай заалт байгаа явдал мөн.

Нууц товчооны 279, 280-р зүйлд: Зуун хоньдоос нэгэн хонин гаргаж мөн зуурт үгэүн (үгээгүй) дутуун-д (ядууд) өгтүгэй.

Зуун хониноос нижээд зусаг гаргаж үгэүн дутуум-д өгвөл сайн бий. Ядуучуудад тусламж өгөх нь урьдаас уламжлалтай байж болох бөгөөд энэ нь ерөөс монгол аймгууд, монголын нэгдсэн улсын төрт ёсны энэрэнгүй бодлого хоёр ёсыг тэгшитгэх (төр, шашин) үзлийн илрэл байжээ.

Өгөдэй хааны үед тогтоосон хуулийн нэг нь 1237 онд гаргасан өртөөний хууль юм.

Тэр хуулийг нууц товчооны 279, 280-р зүйлд тэмдэглэсэн байна. 279-р зүйлд: Бас бид элчинг айл улс хэсүүлэхийг халмой. Уургын улаа элч явахад удаан байна. Улс иргэнийг их зовоож байна. Одоо бид оршуулан (байнга журам болгож) зүг зүгийн мянгат мянгатаас замчин, улаачин гаргая, суурь суурьт зам тавья, элч хадаа үгүй улсаар үл битүүлэн, хэсүүлэн замаар болох уу.

«Хаан, сайд Чаной, Булхадар нарын саналаар урьдах хятан зэрэг аймаг, улсын үлгэр жишээгээр, өртөө байгуулахаар шийдсэн байна.<sup>12</sup>

280-р зүйлд: Замчин, улаачныг гаргая, суурин суурин газар суулгая, зам тавиулж Арачиан, Тогучар хоёроор захируулж, замын нэгэн

суурьт хорин улаачин гаргая. Улааны морь, шүүсний хонь, саалийн сүү, хөллөх үхэр тэрэг биднээс хэнлэксэн (тогтоосон хэмжээ:

Охор буги (шидмэс) дутуулбаас  
Уруулын хагас- (ыг огтолж),  
Алдалтан болтугай,  
Халбуга хикээс дутуулбаас  
Хамрын хагас- (ыг огтолж)  
Алдалтан болтугай! гэжээ.

Нууц товчооны 279-р зүйлээс үзвэл, ХШ зууны үед монголд уургын улаа хөгжиж элч нар нь айл хэсүүчлэн давхиж, ард олныг их хохируулан зовоож байсан учир түүнийг өөрчлөн суурин өртөөг байгуулах нь эрх биш илүү ашигтай гэж үзсэн бололтой.

Нууц товчооны 280-р зүйлд дурдсаныг нягталваас, өртөөний асуудлыг төр, захиргааны хууль зүйлээр зохицуулж байсан боловч өртөөнд хэрэглэгдэх эд зүйлсийг чухалд үзэж түүнийг алга болгох, дутаах зэргээр үрэгдүүлбэл эрүүгээр шийтгэхээр хуульчлан тогтоосон нь тэр үед өртөөний албыг хэрхэн чухалд үзэж байсны нотолгоо юм.

Нууц товчоонд дурдсан урьд өмнө дурдагдаагүй төр, захиргааны хууль зүйлийн нэг чухал зүйл бол хотын даргын тухай юм. Жишээ нь; Нууц товчооны 263-р зүйлд дурдсанаар, Чингис хаан Сартаул улсыг эзэлж дуусаад зарлиг гаргаж хот, хотод дарга тавьсан байдаг. Ингэхдээ Өргнэчи хотоос Хоромши овогтой Сартаул улсыг эзэлж дуу саад зарлиг гаргаж хот, хотод дарга тавьсан байдаг. Ингэхдээ Өргнэчи хотоос Хоромши овогтой Сартаул ялавач, Масхуд хэмээх эцэг хөвүүн хоёр ирж, хот газрын ёс заншлын тухай Чингис хаантай ярилцсан байдаг. Чингис хаан тэднийг хот газрын заншил ёсыг сайн мэдэх тул хөвүүн хороми Масхудыг монгол дарга нарын хамт Бухар, Сэмистяб, Өргнэчи, Удан, Хисгар, Уриан, Гусаадарил зэрэг хотыг захируулаад эцэг Хоромши Ялавачийг авчирч, хятадын Жунду (Бэйжин) хотыг захируулсан байна. Ялавач, Масхуд нар хот суурин газрын журам ёсыг сайн мэдэх тул Хятад улсыг захирах монгол дарга нарын дэргэд Сартаул (Туркестан) хүмүүсийг зөвлөгч нараар томилсон байдаг. Энэ байдал нь XII-XIII зууны үеийн монголчууд хот газрын ёс заншил, журам дүрмийг мэддэг байсан, бас хотын талаар түүний даргыг томилох, даргын дэргэд зөвлөгч нарыг бий болгосон зэрэг нь төр, захиргааны нэлээд боловсронгуй бодлого явуулж байсны тодорхой гэрч юм. Нөгөө талаар монголчууд нүүдэлчин аймаг байсан учраас ерөөс хот, суурин газрын тухай ойлголт мэдлэг байгаагүй мэтээр бичдэг зарим хүмүүсийн үзэл бодлыг энэ баримт няцааж байна.

Нууц товчоонд үлдсэн төр, захиргааны холбогдолтой нэг сонирхолтой зүйл бол ХП—ХШ зууны үеийн монголчуудын нутаг бэлчээр хуваарилах, газрыг өмчлөх, газар нутгийн тухай хууль юм.

Нууц товчоонд үлдсэн төр, захиргааны холбогдолтой эртний үлдэц нь овог, аймгууд өөр, өөрсдийн хариуцсан дэвсгэр нутагтаа ан гөрөө хийх ёс юм. Нууц товчооны 9-р зүйлд бичсэн нь: Хорилардай мэргэн, хорь түмдийн газартаа булга, хэрэм, гөрөөтэй газраа булаалдан муудалцаж, Хорилар овогт болж Бурхан халдунд ан гөрөөс сайтай газар хэмээн Бурхан халдуны эзэн Бурхан болгосон Шинч баян Урианхайд нүүж айсуу ажээ.

Эндээс үзхүл ХП зууны үед Монгол овог тус бүрдээ нутагтай тэр дэвсгэр нутагтаа ан гөрөө хийдэг, хэрвээ нэг овог нөгөө овгийн нутагт ан гөрөө хийвэл түүнийгээ булаалдаж харилцан маргалддаг тухай аман хэв хуультай байсан бололтой. Нэгэнтээ бэлчээр нутгийг

овог аймгууд хувааж өөр өөрсдийн мэдэлдээ авдаг байсан учир чухамдаа ХП-ХШ зууны үед монголчууд газрыг хувьдаа өмчилж байсан хэмээн хэлж болох үндэстэй юм.

ХШ зууны эхээр монгол аймгуудын нутаг дэвсгэр нь овог, аймгуудын хэмжээгээр бүрэн нэгдмэл болж чадаагүй байсан боловч дотроо мянгат, түмэт, аравт гэсэн цэрэг-засаг захиргааны шинжтэй нэгдэлд хуваагдаж байсан боловч улс, иргэнд хуваасан нарийн хуваарьтай болоогүй, өөрөөр хэлбэл овог, аймгийн газар эзэмшил, газар эдлэнгийн хэв хууль нэлээд илүү хүчинтэй үйлчилж байжээ. Энэ учир ХШ зууны эхээр Өгөдэй хаан газар нутгийн тухай хууль гаргасан байна. Нууц товчооны 279-р зүйлд: Бас улс иргэнд нутаг ус хувааж өгье. Нутаг нутаглуулхуяа Мянгат мянгатаас нутагчин ялгаж гаргавал болох буюу? Бас: цөл газарт гөрөөснөөс бусад (амьтан) байхгүй. Иргэн ахуяа (байхад) Соод (-той) Чаной Тууртай хоёр нутагчныг тэргүүлж, цөлийн худгууд эрүүлж (малтуулж) хаштугай!

Нууц товчоонд дурдсанаас үзвэл, тэр цагт Чингис хаан зарим ноёдод дархан олгосон соёрхол газар нь монгол нутгийн өчүүхэн хэсгийг эзэлж байсан бололтой.

Энэ учраас Монголын тэр үеийн ихэнх нутаг нь Мянгадын газрын хуваарь тогтоож амжаагүй байжээ. Үүнээс уламжлан Өгөдэй хаан, нутаг усыг мянгатдаа хувааж нутаглуулж, бэлчээрийн газар нутгийг тэлж, усгүй зарим цөл нутгийг усжуулах, говьд худаг малтуулах хууль гаргажээ. Энэ нь монголын нутаг дэвсгэрийг зөв оновчтой хуваарилан улмаар газар нутгаа эзэмших, монголын нүүдлийн мал аж ахуйг бэлчээр нутаг усаар хангахад чухал ач холбогдолтой явдал болсон байна.

Нууц товчоонд буй төр эрхийн холбогдолтой зүйл бол боолын тухай юм. Монголд гэрийн боол (зарц) гэдэг ухагдахуун хэзээнээс байсан байна. Энэ нь Монголд болон эзэмших үйлдвэрлэлийн арга бүрэлдэн тогтож байгаагүй боловч гэрийн боолчлол тодорхой хэмжээгээр оршин байж тэр нь феодалын үйлдвэрлэлийн харилцааны хөгжилд зохих үүрэг гүйцэтгэсэн байна. Монголын язгууртнуудад зарц (боол) байсан тухай нууц товчооны 16, 39, 185-р зүйлүүдэд дурдсан байдаг. Нөгөө талаар нууц товчооны 186-р зүйлд дурдсанаар, монголын феодалууд харьяат иргэдээ өөрсдийн өмчид тооцож байсан бололтой. Гэсэн хэдий боловч Монголд боол иргэнээ эзэмших нь боол эзэмших нийгмийн эдийн засгийн хэлбэршлийн үндэс суурь болохуйц тийм хэмжээнд хүрээгүй юм.

**Гэр бүлийн эрхийн холбогдолтой зүйл нь гэр бүл бололцох, инж өгөх, асрамж, тэтгэвэр тэтгэмж олгох явдал мөн.**

Нууц товчооны 18, 43, 168, 185-р зүйлд: нөхөргүй хүүхнээс хүүхэд төрөх, эр, эм бололцох, инж өгөх болон үр хүүхдийн тухай заасан байна. Энд дурдсанаас үзвэл монголчууд бэлбэсэн эмтэй явалдах, нөхөргүй эмэгтэй хүүхэд төрүүлэхийг ихэд цээрлэж байсан бололтой.

Монголчууд ХП зууны эхээр гэр бүлийн асуудлыг төрийн хуулиар биш заншлын эрхээр зохицуулж байжээ.

Монголд эр, эм бололцохдоо инжид нь эд хөрөнгө өгөхөөс гадна эмэгтэй хүнийг өгдөг байсан байна.

Нууц товчооны 43-р зүйлд: Тэр Хабич эхийн инжид ирсэн Бодончарын татвар эм билээ.

Нууц товчооны 168-р зүйлд: «Багалзуур идэх» тухай дурдсан байдаг бөгөөд залуу эр, эм гэрлэсэн өдрөөс эхлэн гурван хоног хонины хүзүү багалзуурыг идэх заншил Монголд одоо ч хүртэл байдаг байна. Хүзүү багалзуурын яс маш бат хэлхээтэй байдаг тул үүгээр эр,

эмийн бат холбоог бэлэгджээ. Иймийн тул «Багалзуур ид» гэх нь эр, эм болох хурим хийе гэсэн үг биз<sup>13</sup> гэж академич Ц. Дамдинсүрэн бичжээ.

Энэ нь монголын нэгдсэн улсаас өмнө эр, эм бололцох тухайг заншлын эрхээр зохицуулж байсны үлдэц юм.

Монголын нэгдсэн улс байгуулагдсаны дараа гэр бүлийн асуудлыг төрөөс зохицуулж эхлэн болсон байна. Нууц товчооны 185-р зүйлд: Чингис хаан Хадаг баатарын амийг соёрхож Хадаг баатар ба Хуйлдарын эм хөвүүнд Жүрхин овгийн зуун хүнийг зарц болгон өгч тэднээс хөвүүн төрвөл Хуйлдарын ургийн ураг хүртэл дагаж явах охин төрвөл эцэг, эх нь өөрийн дураар худалдаж (хадамд өгч болохгүй тухай зарлигласныг дурдсан байдаг.

Нууц товчоонд дурдсанаар, асрамж тогтоох явдал бол монголын ард түмний дотор дээр үеэс уламжлалтай байжээ. .

Нууц товчооны 114, 119, 135, 138-р зүйлүүдэд, мэргэдийн хүчү, тайчуулын Хөхөчү, татаарын Шигихутаг, Жүрхиний Борохул нарыг бага байхад нь нутгаас нь олж авч Өэлүн эхэд авчирч асрамжуулан хөлийг нь дөрөөнд, гарыг нь ганзганд хүргэсэн тухай бичсэн байдаг. Энэ нь Өэлүн эхийн хэлсэн үгнээс тодорхой харагдаж байгаагийн зэрэгцээ тэдгээр нь монголын нэгдсэн улсын үеэс эхлэн хаандаа үнэнчээр үйлчилж улмаар Чингис хаанаас соёрхол хүртэж байсан зэргээр нотлогдож байна. Жишээ нь нууц товчооны 138-р зүйлд: Өэлүн эх бусдын нутгаас олж авсан хөвүүддээ: Өдөр үзэх нүд, шөнө сонсох чих болгоё гэж гэртээ тэжээв гэсэн нь Өэлүн эх тэдгээр хүүхдүүдийг хэрхэн элэгсэг дотно байдлаар асарч хүмүүжүүлэн эцэст нь тэдэнд өөрийн удмын үзэл бодлыг бат шингээж тэд монголын эзэнт улсад хэрхэн үнэнчээр хүчин зүтгэж Өэлүн эхийн тэжээсэн ачийг хэрхэн хариулж байсныг нууц товчооноос мэдэж болох байна. Нууц товчооны 214-р зүйлд дурдсанаар Чингис хаан Борохулд хэлэхдээ:

Эх минь Шихихутуг, Борохул, Хүчү, Хөхөчи та дөрвийг иргэний нутгаас

Хөсрөөс олж

Хөлдөө дүрж,

Хөнжилөн асарч тэжээрүүн

Хүзүүнээс тань татаж

Хүн лүгээ сацуу болгож

Эгэмнээс тань татаж

Эр лүгээ сацуу болгож

Хөвгүүдийн маань нөхөр сүүдэр болгосу хэмээн тэжээв. Таныг тэжээсэн ачаа эхэд их миний хэдүй ач тус хариулав Та!

Энэ бүхэн нь чухамдаа эх эцэг нь үр хүүхдээ тэжээх, үр хүүхэд, нь эцэг, эхээ тэжээх ёстой гэсэн хууль зүйн хувьд үүрэг болгосон шинжийг агуулж байна.

ХШ зууны эхэн үед Монголын хаан төрийн хэрэгт хүчин зүтгэж яваад амь үрэгдэгсдийн ар гэрт тэтгэвэр өгөх хуультай байжээ. Нууц товчооны 185, 217, 218-р зүйлүүдэд дурдсан байна. Энэ тухайг Х. Пэрлээ тодорхой бичсэн учир энд давтах хэрэггүй юм.

Харин өнчрөгсдөд өгөх хишиг нь нэг удаагийн буюу үүрд авах хоёр янзын байсан байна. Жишээ нь нууц товчооны 185, 219-р зүйлд: Хуйлдар болон Наринтоорилд хаан төрийн төлөө зүтгэсний тулд ургийн ураг хүртэл өнчдийг тэтгэх хишгээс үүрд хүртэх эрх олгосон

байхад 217-р зүйлд: Хуйлдарын хөвүүд, ач нарт өнчдөд олгох өршөөл тусламжийг нэг удаа хүртээснээр бичсэн байна.

Монголын хууль цаазны эрт, дундат үеийн эдгээр зарим зүйл нь ХШ зууны үеийн монголын нийгмийн байдал, давхаргын шинж чанарыг зөв тодорхойлох хууль цаазын хөгжил уламжлалыг шинжлэхэд нэн чухал хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй.

---

<sup>1</sup> Х. Пэрлээ. Нууц товчоонд үлдсэн хууль цаазны зарим зүйл «Монголын судлал» УБ., 1962, 3-р боть, 15-р дэвтэр

<sup>2</sup> Мөн дурдсан бүтээл

<sup>3</sup> Мөн дурдсан бүтээл

<sup>4</sup> Мөн бүтээл

<sup>5</sup> Мөн бүтээл

<sup>6</sup> В. А. Рязановский «Монгольское право», Харбин, 1931, с. 15

<sup>7</sup> Ш, Нацагдорж, Монголчуудын өв өвлөх эрх, УБ, 1971 5 дахь тал

<sup>8</sup> Х. Пэрлээ. Нууц товчоонд үлдсэн хууль цаазны зарим зүйл «Монгол судлал» УБ., 3-р боть, 15-р дэвтэр

<sup>9</sup> Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1988, 72 дахь тал

<sup>10</sup> Чингис хааны товчоон. Өвөрмонгол, Хөх хот. 1987 он, Хавсралт хуудас 1123—1152

<sup>11</sup> С. А. Козин, Сокровенное сказание. М., 1941 с. 14

<sup>12</sup> х, Пэрлээ. Нууц товчоонд үлдсэн хууль цаазны зарим зүйл, «Монголын судлал», 4 УБ., 1962, 3-р боть, 15-р дэвтэр

<sup>13</sup> Монголын нууц товчоо. УБ., 1976, 113 дахь тал